



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,
E-mail: info@mrtd.gov.mn, http://www.mrtd.gov.mn

2017. 01. 31 № 01/417

танай _____ -ны № _____ -т

Г Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний тайлан хүргүүлэх тухай

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийг 2016 оны жилийн эцсийн байдлаар гарган хүргүүлж байна.


2016 онд тус яамны хариуцсан 22 зорилтыг хэрэгжүүлэх 48 арга хэмжээг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу дүгнэхэд дунджаар 85.4 хувийн биелэлттэй гарлаа.

Хавсралт 27 хуудастай.

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан 4 хуудас;
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 23 хуудас.



Боловсруулсан: Н.Буянт
Нийлсэн
2% Ц.Н
2017.02.03



Зам, тээврийн хөгжлийн яамны 2017 оны
01 дүгээр сарын 31 -ний өдрийн 4/7
тоот албан бичгийн Хавсралт №1

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ¹⁹⁴⁸⁷
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН¹¹¹⁶¹²⁶⁷⁸¹
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

2017.01.25

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт даалгасан Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол болно.

Дээрх тогтоол, тушаалтын заалтын дагуу энэхүү хяналт-шинжилгээний тайланг, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг гол үзүүлэлт болох ач холбогдолтой юм.

Хяналт-шинжилгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх төвшин, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлоогүй учир 2017 онд хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлтийн 1/3(гуравны нэг)-т тооцож, төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшинг үнэлэв.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтоохдоо Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2014 оны 116 дугаар тушаалаар баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ыг баримталсан болно.

ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Зам, тээврийн хөгжлийн сайдын “үндсэн хэрэгжүүлэгч байгууллага” буюу дангаар болон толгойлон хэрэгжүүлэх 125, бусад байгууллага, Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 28, оролцон хэрэгжүүлэх 22 арга хэмжээ, нийт 175 арга хэмжээ тусгагдсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж дуусгах хугацаагаар нь ангилж үзүүлбэл:

2016 -2020	2017 он	2018 он	2019 он	2020 он	
		2.107.1, 2.107.4, 2.107.13, 2.107.16, 2.107.18, 2.107.14, 2.107.15, 2.107.32, 2.109.2, 2.114.8, 2.114.9, 2.114.14, 2.114.16, 2.116.2, 2.118.6, 6.4.1.1, 6.19.2.2	2.107.5, 2.107.6, 2.107.7, 2.107.24, 2.107.27, 2.107.28, 2.107.30, 2.113.2, 2.114.7, 2.114.13, 2.114.15, 2.115.4, 2.118.3, 2.118.4, 6.2.1.1, 6.3.1.1, 6.8.2.1, 6.9.1.1, 6.9.1.2, 6.9.1.3, 6.9.1.4, 6.16.1.1, 6.16.1.2, 6.16.1.3, 6.19.1.1, 6.19.3.3,	2.107.2, 2.107.3, 2.107.8, 2.107.9, 2.107.10, 2.107.11, 2.107.12, 2.107.17, 2.107.19, 2.107.20, 2.107.21, 2.107.22, 2.107.25, 2.107.26, 2.107.29, 2.107.31, 2.107.33, 2.107.34, 2.107.35, 2.108.2, 2.109.1, 2.110.1, 2.111.2, 2.111.3, 2.111.4, 2.112.1, 2.113.1, 2.114.1, 2.114.2, 2.114.3, 2.114.4, 2.114.6, 2.114.10, 2.114.11, 2.114.12, 2.114.17, 2.115.1, 2.115.2, 2.115.3, 2.116.1, 2.117.1, 2.117.2, 2.117.3, 2.117.4, 2.118.1, 2.118.2, 2.118.5, 2.118.7, 2.119.1, 2.119.2, 2.120.1, 2.121.1, 2.121.2, 2.121.3, 2.121.4, 3.2.33.7, 4.1.3.6, 4.4.5.2, 5.1.3.1, 5.6.1.5, 5.6.1.6, 5.6.5.2, 6.1.1.1, 6.7.1.1, 6.8.1.1, 6.14.1.1, 6.16.1.5, 6.16.1.6, 6.16.1.7,	
125	12	26	18	69	

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 онд толгойлон хэрэгжүүлэх 48 арга хэмжээний биелэлт жилийн эцсийн байдлаар **дунджаар 85.4** хувьтай байна.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг яамны газар, хэлтсийн хариуцсан асуудал тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Үнэлгээ	БТГ	ТЗДТБХЗГ	АЗБХЗГ	АТБХЗГ	АТБХЗХ	ХШУДАГ	НИЙТ
100%	2.107.22, 2.118.7, 6.14.1.1		2.107.14, 2.107.22, 2.107.32, 6.14.1.1	2.120.1	2.114.8, 2.116.2,	2.107.14, 2.107.32, 2.114.8	
	3	-	4	1	2	3	8
90%	2.107.18, 2.111.2, 2.116.1, 2.118.1, 2.118.2, 2.121.2, 2.121.4, 2.118.5, 3.233.7, 5.1.3.1, 5.6.5.2	2.110.1, 2.111.1, 2.111.2, 2.111.4, 2.113.2, 2.114.1, 2.116.1, 2.118.1, 5.1.3.1,	2.107.1, 2.107.15, 2.107.18, 2.116.1, 2.121.1, 5.1.3.1, 2.121.2, 2.121.4, 6.19.2.2	2.116.1, 2.118.2, 2.118.5, 5.1.3.1,	2.114.16, 2.116.1, 2.114.17, 2.115.1, 5.1.3.1,	2.116.1, 5.1.3.1,	
	11	9	9	4	5	2	23
70%	2.114.2, 2.118.6, 4.4.5.2, 5.6.1.5,	2.108.1, 2.108.2, 2.112.1, 2.117.4, 5.6.1.5	2.107.4, 2.107.16, 2.107.23,	2.118.6, 4.4.5.2,	2.114.2, 2.114.7,		
	4	5	3	2	2	-	12
50%	5.6.1.6	5.6.1.6		5.6.1.6			
	1	1	-	1	-	-	1



0%							
Үнэлэх боломжгүй	2.121.3, 6.14.2.2, 6.16.1.1		2.121.3, 6.14.2.2, 6.16.1.1		2.114.9		0
	3	-	3	-	1	-	4
Нийт арга хэмжээний дундаж	85.3	80.7	88.7	81.2	87.8	96	85.4

ДҮГНЭЛТ

1. Хэрэгжилтийн хувьд авч үзвэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 8 арга хэмжээ “бүрэн хэрэгжсэн”, 1 арга хэмжээ “төлөвлөсөн хугацаанаас хоцролтой” хэрэгжиж байна. Хоцролтой арга хэмжээнд 50 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Үүнд:

- БНХАУ-ын нутаг дэвсгэрээр далайд гарах, дамжин өнгөрөх, олон улсын зэрэглэл бүхий авто болон төмөр замын боомт нэмж байгуулах асуудлыг хамтран шийдвэрлэх-50%.

2. Дараах 4 арга хэмжээг “үнэлэх боломжгүй” гэж үзлээ. Үүнд:

2.1. Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Арвайхээр, Улаанбаатар-Чингис, Налайх-Чойр, Хархорин-Цэцэрлэг, Улаангом-Хандгайт, Өлгий-Улаан байшинт чиглэлийн 725 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэх/2016 оны улсын төсөөт авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх хөрөнгө тусгагдаагүй/;

2.2. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах;

2.3. Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 112 км авто зам барих /2.2, 2.3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар хуралдааны тэмдэглэлээр эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөөт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил эхлээгүй авто замуудын барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулах шийдвэр гарсан бөгөөд 2016 онд барилгын ажил хийгдээгүй, концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан тухайн чиглэлийн авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газар хариуцаж байгаа бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд уг төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих эрх одоогоор шилжиж ирээгүй/;

2.4. Завхан аймгийн “Доной” нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурvas, үерийн далан байгуулах /Санхүүжилтийн эх үүсвэр нь батлагдаагүй тул 2016 онд ажил гүйцэтгээгүй/.

3. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.107.22 арга хэмжээ 6.14.1.1 дэх арга хэмжээтэй давхардсан, 6.19.2.2 дахь арга хэмжээ нь 2.107.1 дэх арга хэмжээнд бүхэлдээ багтсан байна.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2017 онд 126 км авто замд их засвар шинэчлэлтийн ажил, 181 км авто замд ээлжит засварын ажил, 282,1 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлтийн ажил хийхээр хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд тусгасан байх тул 2017 оны төсвийн тодотголд шаардлагатай хөрөнгийг тусгах талаар ажиллах;

2. Цаашид яамны холбогдох газрууд төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлж дуусах хугацаатай нь уялдуулан хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ



Зам, тээврийн хөгжлийн яамны 2017 оны
01 дүгээр сарын 31 -ний өдрийн 4/17
тоот албан бичгийн Хөөрөлт №2

УХА0382
5919487
1116126781

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/Зам, тээврийн хөгжлийн яам, 2016 оны жилийн эцсийн байдлаар/

ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	2017 он		ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	Хувь
						Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв		

Тэргүүлэх зорилт №2.6. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

2.107. Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хүчилттай авто замын сүлжээг өргөтгэж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хүчилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ.	1	Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км хатуу хүчилттай авто замын барих АЗБХЗГ	2016-2018	Улсын төсөв, гадаад эх үүсвэр	114 300	Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь	57 150	<p>1. Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанийт барилгын ажлын гэрээ байгуулсан. 2018.08.30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн. Одоогоор хөрс хуулалт 85,71%, далангийн дүүргэлт 66,7%, ухмал 14,58%, сууриний доод үе 42.53% хийгдсэн. Нийт барилгын ажил 17.2%-тай байна.</p> <p>2. Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр "НКВ интернейшнл холдинг" ХХК-тай барилгын ажлын гэрээ байгуулсан. 2018.08.30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн. Одоогоор хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 79,57%, ухмал 96,93%, сууриний доод үе 72.28%, гүүрийн ажил 30.54%, хоолойн ажил 23.05% хийгдсэн. Нийт барилгын ажил 27.44%-тай байна.</p> <p>3. Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанийт барилгын ажлын гэрээ байгуулсан. 2018.08.30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Барилгын ажил 2016 оны 06 дугаар сард эхэлсэн. Одоогоор хөрс хуулалт 38,28%, далангийн дүүргэлт 14.10%-тай байна. Нийт барилгын ажил 7.22%-тай байна.</p> <p>4. Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанийт барилгын ажлын гэрээ байгуулсан. 2017.08.30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад гомдол гарсан бөгөөд Захиргааны хэргийн шүүхээр</p>	90%
--	---	--	-----------	-------------------------------	---------	----------------------------------	--------	---	-----

							яаманд 2016.03.23-ны өдрийн 02/1353, 2016.03.25-ны өдрийн 02/1411, 2016.08.26-ны өдрийн 9-2/5339 тоот албан бичгээр тус тус хүргүүлж шийдвэрлүүлэв. АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн гадаад ажиллах хүчиний зөвшөөрөл, ажиллах хүчиний төлбөрөөс чөлөөлүүлэх асуудлыг Засгийн газрын 2016.03.28-ны өдрийн 181, 2016.04.11-ний өдрийн 209, 2016.05.23-ны өдрийн 277 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлүүлэв. Мөн барилгын ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх, төслийн хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх талаар хөрөнгө оруулагч байгууллага болох АХБ болон Сангийн яамтай хамтарсан Харилцан ойлголцлын санамж бичгийт 2016.04.12, 2016.10.05-ны өдөр тус тус байгуулж ажиллав. Төслийн "Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх" зөвлөх үйлчилгээний 101 дугаар бүхий гэрээг 2016.04.01-ний өдөр, зөвлөх үйлчилгээний 101/140 дугаар бүхий нэмэлт гэрээг 2016.06.14-ний өдөр, Төслийн бус нутагт эрүүл, мэнд, аюулгүй байдал, хүний наймаа, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, ДОХ/Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөх үйлчилгээний 02 дугаар бүхий гэрээг 2016.08.22-ны өдөр тус тус байгуулав. Ажлын талбайд урьдчилан тодорхойлдоогүй археологийн олдвор, шилэн кабель асуудал гарч шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх асуудал эх үүсвэр байхгүйгээс удааширсан бөгөөд хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх талаар АХБ-нд удаа дараа асуудал тавьсны дунд барилгын ажлын магадалшгүй ажлын зардлаас шийдвэрлэх зөвшөөрөл авч ажлыг эрчимжүүлсэн.	
4	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.5 км хатуу хүчинтэй авто замыг барих АЗБХЗГ	2016-2018	Гадаад зээл	86 100	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь	60 270	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хүчинтэй авто замын барилгын ажлыг Засгийн газрын 2015 оны 309 дүгээр тогтоолоор БНХАУ-ын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэгчээр шалгарсан Shanghai Construction Group Co.,Ltd-тай 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 105 тоот гэрээг байгуулсан. Зам барилгын ажлын хяналтын зөвлөх компанийг мөн холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, шалгарсан "Гуанжу Ванан Констракшн Супервишин" ХХК-тай 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулсан. Тус зам барилгын ажлыг хэрэгжүүлэх зээлийн тусгайлсан хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хооронд 2016 оны 07 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу авто замыг барилгын ажил эхэлснээс хойш 18 сарын хугацаанд хэрэгжүүлж ашиглалтад оруулна. 2016 онд барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, улаан шугам хүлээн авах, трассын хэмжилт, кемп болон карьеерын байршил тогтоох ажил, кемпийг барьж байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 2017 онд зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг хангасан.	70%

14	Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хүчилттай авто замыг барих АЗБХЗГ, ХШУДАГ	2016-2017	Төр, хувийн хэвшлийн түншлэл	283 920	Барилгын ажлыг дуусгах	70 980	<p>Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны хөтөлбөрийн хүрээнд МУ-ын Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 87 дугаар тогтоол гарсан бөгөөд хуучнаар Хөрөнгө оруулалтын газар, хөрөнгө оруулагчийг төлөөлж "Лунзянь Роуд Энд Бридж" ХК нь 2015.03.13-ны өдөр Алтай-Дарви чиглэлийн 165 км, 2015.03.25-ны өдөр Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хүчилттай авто замыг барих, шилжүүлэх (BT) концессын гэрээг байгуулсан.</p> <p>Уг төслийн барилгын ажил 2016 оны 10 сард дууссан бөгөөд 98 км авто замыг улсын ашиглалтад оруулаад байна. Үлдсэн 165 км хатуу хүчилттай авто замд Улсын комисс ажиллаж, зөрчил, дутагдал илэрсэн тул үүрэг даалгавар өгсөн.</p>	100%
15	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хүчилттай авто замыг барих АЗБХЗГ	2016-2017	Гадаад зээл	28 980	Барилгын ажлыг дуусгах	24 840	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлын санхүүжилтийн асуудлыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хэмнэгдсэн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр Засгийн газарт танилцуулан 2016.08.31-ний өдрийн 44 дүгээр хуралдааны тэмдэглэл гарсан боловч эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Барилгын ажил 60%-тай	90%
16	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хүчилттай авто замыг барих АЗБХЗГ	2016-2018	Гадаад зээл	83 500	Барилгын ажлын гүйцэтгэл 80 хувь	66 800	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг Засгийн газрын 2015 оны 309 дүгээр тогтоолоор БНХАУ-ын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэгчээр шалгарсан Xinjiang Beixin Road and Bridge Group Co.,Ltd -тай 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 105 тоот гэрээг байгуулсан. Зам барилгын ажлын хяналтын зөвлөх компанийг мөн холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, шалгарсан "Гуанжу Ванан Констракшн Супервишн" ХХК-тай 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулсан. Тус зам барилгын ажлыг хэрэгжүүлэх зээлийн тусгайлсан хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хооронд 2016 оны 07 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу авто замыг барилгын ажил эхэлснээс хойш 18 сарын хугацаанд хэрэгжүүлж ашиглалтад оруулна. 2016 онд барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, улаан шугам хүлээн авах, трассын хэмжилт, кемп болон карьеरын байршил тогтоох ажил, кемпийг барьж байгуулах, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж, байршуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 2017 онд зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг хангасан.	70%
18	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хүчилттай авто	2016-2018	Төр, хувийн хэвшлийн түншлэл	148 700	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь	104 090	<p>МУ-ын Засгийн газрын 2016 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 213 дугаар тогтоолоор концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх 86'508'551.00 ам.долларын өртөгтэй "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хүчилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээг "Хос мөнгөн зам" ХХК-тай байгуулах эрхийг хуучнаар Хөрөнгө оруулалтын газарт олгосон байна.</p> <p>2016 онд МУ-ын Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй</p>	90%

	замыг барих АЗБХЗГ, БТГ					холбогдон 2016.07.22-ны өдрөөс эхлэн Хөрөнгө оруулалтын газрыг Үндэсний хөгжлийн газарт нэгтгэж өнөөдрийг хүртэл концессын гэрээ байгуулаагүй боловч барилгын ажил 65% гүйцэтгэлтэй байна. Уг замын газар шорооны ажил болон хиймэл байгууламжийн ажил бүрэн дууссан бөгөөд суурь 62 км, суурь хучилт 35 км тус тус хийгдээд байна. МУ-ын Засгийн газрын 2016.12.28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлээр уг авто замын барилга угсралтын ажлыг гэрээг байгуулж, 2017 онд үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн.		
22	Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хүчинтэй авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах АЗБХЗГ, БТГ	2016-2020	Улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл	143 086	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь	14 308	Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302.7 км хатуу хүчинтэй авто замын барилгын ажлыг Өмнөговь аймаг орон нутгийн хөрөнгөөр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгчээр "Дарданговь" ХХК ажиллаж байгаа бөгөөд эхний 56 км авто замыг барьж улсын ашиглалтад оруулсан.	100%
23	Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн 32 км хурдны авто замыг барьж дуусгах АЗБХЗГ	2016-2018	Гадаад зээл	154 000	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь	83 700,0	Авто замын барилгын ажил 2016.04.18-ны өдөр эхэлсэн. Гүйцэтгэгч байгууллагын гадаадаас авах 300 ажиллах хүчиний асуудлыг МУ-ын Засгийн газрын 2016.02.01-ний өдрийн 84-р тогтоолоор шийдвэрлүүлсэн. Мөн 2015 онд импортоор оруулж ирэх бараа, материал, тоног төхөөрөмжийн асуудлыг ГЕГ болон Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлсэн. МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2016.05.05-ны өдөр Төслийн барилгын ажлын тусгайлсан зээлийн хэлэлцээр, 2016.07.14-ний өдөр Зөвлөхийн үйлчилгээний тусгайлсан зээлийн хэлэлцээрийг тус тус байгуулсан. НЭДТГ-ын төлөөлөлтэй хуралдаж хурдны замын нийслэл дэх хэсгийн трассыг тохиорлцсон бөгөөд авто замын зураг төсөл батлагдсан. Одоогоор км0+000-ээс км22+600 хүртэлх хэсгийн зам барилгын ажлыг Ерөнхий гүйцэтгэгч, км22+600-аас км32+226 хэсгийн зам барилгын ажлыг зээлийн гэрээний дагуу дотоодын туслан гүйцэтгэгч компаниуд гүйцэтгэж байна. Урьдчилгаа төлбөрийн баталгааг Сангийн яаманд хүргүүлсэн. Нийт зам барилгын ажлын гүйцэтгэл 15% орчим хувьтай байна.	70%
32	Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын 72.8 урт метр төмөр бетон гүүрийг барих АЗБХЗГ, ХШУДАГ	2016-2017	Улсын төсөв	3 100	Гүүрийг барьж ашиглалтад оруулах	3 100	Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын 72.8 урт метр төмөрбетон гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Эйч Кэй Би Интернэйшил Холдинг" ХХК-ийг сонгон шалгаруулсан бөгөөд тус компани гүүрийн барилга угсралтын ажлыг бүрэн хийж дуусган улсын ашиглалтад 2016 оны 11 сард хүлээлгэн өгсөн.	100%

	2.108. “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барж ашиглалтад оруулна.							
1	“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замыг барих ТЗДТБХЗГ	2016-2018	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн н түншлэл	2 386 380	Зураг төслийг боловсруул ж бүрэн дуусгах, барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь	1 312 510	<p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын газар шорооны ажил 86.6%, гүрийн ажил 53.1%, холойн ажил 52.7%, төмөр бетон дэрний үйлдвэрийн ажил 90%, бэхэлгээ нийлүүлэлт 6%, хайрга олборлолт /балласт/ нийлүүлэлт 44%-тай нийт ажил 51.84%-тай явж байна.</p> <p>Барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай 1.3 тэрбум ам.долларын санхүүжилтийн талаар БНХАУ-ын экспорт-импортын банктай гэрээ хэлэлцээр хийх зээлээгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай Засгийн газрын 2016 оны 109 дугээр тогтоол батлагдсан. Энэ чиглэлийн төмөр замын ажлыг дотоодын эх үүсвэрээс бэлтгэл ажлыг хангах талаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж 2016.03.03-ны 01/860 тоот албан бичгээр холбогдох яамдаас санал авч ЗГХЭГ-т Засгийн газрын хуралдаанд оруулахыг хүссэн 2016.03.07-ны 01/885 тоот албан бичиг хүргүүлсэн. Түүнчлэн БНЭУ-ын 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг санхүүкуулэхээр ажиллаж байна. Мөн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн доод бүтцийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх, эрчим хүчиний ажлыг эхлүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж СЯ, Х3Я, ГХЯ-наас санал авахаар 2016.06.06-ны өдрийн 01/2449 тоот албан бичиг хүргүүлсэн. Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын хил нэвтрэлэх цэгийн асуудлаар Монгол Хятад улсын хилийн 700-703 дугаар тэмдгийн аль тохиromжтой цэгээр нэвтрүүлэх саналыг Боомтын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж хуралдааны тэмдэглэлд тусгасан.</p> <p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хийгдээд байгаа барилгын ажлын гүйцэтгэлийг байгалийн нөлөөнд автсан эсэх, барилгын ажлыг үргэлжлүүлэхэд гарах сөрөг үр дагавар, сэргээн засварлахад гарах нэмэгдэл зардал зэргийг судлахаар хяналт шалгалт хийж ажлын хэсгийн дүгнэлт гарган танилцуулсан. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-т 2016.09.13-ны өдрийн 01/953 тоот дугаараар хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй болно. Монгол Ерөнхий сайдын 2016 оны 104 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг Тавантолгойн орд газар болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажилд хөрөнгө оруулж хамtran ажиллах БНХАУ-ын Шинхуа компанийтай гэрээ хэлэлцээр хийж байна.</p>	70%
2	“Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх	2016-2020	Гадаад зээл, хувийн хэвшлийн н хөрөнгө оруулалт	2 386 380	ТЭЗҮ, зураг төслийг боловсруу- лах, барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь	477 276	<p>Монгол Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тодотгол хийж Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн царигийн өргөнийг 1435 мм байхаар шийдвэрлэсэн.</p> <p>Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шугамын чигийг Засгийн газрын 2016 оны 146 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлуулсан. “Монголын төмөр зам” ТӨХК, БНХАУ-ын “Башинь төмөр зам” ХХК хооронд байгуулсан хамtran ажиллах санамж бичгийн хүрээнд дээрх чиглэлийн</p>	70%

		ТЗДТБХЗГ					төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар товчоо боловсруулж дууссан. “Хөөт-Бичигт” чиглэлийн 234 км төмөр зам барих төслийг тулхүүр гардуулах нөхцлтэй гэрээгээр хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2017 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулан ажил эхлүүлэх тухай тогтоолын төсөл боловсруулж Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоолоор батлуулж, СЯ, “Монголын төмөр зам” ТӨХК-тэй хамтарсан үнэлгээний хороо байгуулахаар ажиллаж байна.	
2.110. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.	1	“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх ТЗДТБХЗГ	2016-2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 295 540	Зураг төслийг боловсруулж дуусгах	6 000 Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 61 дүгээр тэмдэглэлээр Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн царигтай барьж байгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллах тухай тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Тэмдэглэлийг хэрэгжүүлж “Төреөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулан үзэл баримтлалыг Хууль зүйн дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд хамтран баталж, тогтоолын төслийг Засгийн газар 2016.12.27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Төслийг тулхүүр гардуулах нөхцлтэй гэрээгээр хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2017 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулан ажил эхлүүлэх тухай тогтоолын төсөл боловсруулж Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоолоор батлуулсан. Төмөр замын чиглэл болон царигийн асуудлыг УИХ-аар хэлэлцүүлж дэмжигдэж, батлагдсаны дараа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хийнэ.	90%
2.111. Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	1	Улаанбаатар төмөр замын галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах автомат хориглолын систем, диспетчерийн төвлөрүүлэлт нэвтрүүлэх ТЗДТБХЗГ	2016-2018	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, бусад эх үүсвэр	120 000	УБТЗ-ын тээх, нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх	60 000 “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Ерөнхий хорооны хурлаас Улаанбаатар төмөр замын 2020 он хүртэлх хэтийн техникийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахаар шийдвэрлэсний дагуу ОХУ-ын Ерөнхийлөгчийн МУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр Зам, тээврийн яам “Оросын төмөр замууд” ХНН “Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн хэлэлцээр”-ийг байгуулсан. Хэлэлцээрт Улаанбаатар төмөр замын сүлжээг анх удаа эдийн засгийн үндэслэлтэйгээр үндсэн 4 чиглэлээр өргөжүүлэх, хөгжүүлэх, дамжин өнгөрөх тээврийг үлэмж нэмэгдүүлэх, зохион байгуулах төсөл, арга хэмжээнүүдийг тохиролцсон. Шинэчлэлийн хөтөлбөрийн дараагийн үе шат болох дохиолол, холбооны зураг төслийн даалгавар батлагдан зураг төслийн ажил хийгдэж дууссан. “УБТЗ” ХНН-ийн дохиолол, хориглол, төвлөрүүлэлтийн шинэчлэлийн “Элтеза” компанитай 2015.10.29-ны өдөр байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэгч компани төмөр замын шугам замд судалгааны ажлыг хийж дуусгасан ба дараах чиглэлүүдээр батлуулсан ажлын даалгаврын дагуу зураг төслийн ажил хийгдсэн. Үүнд: гол тоологчийн тусламжтайгаар хоорондын замын чөлөөтэй байдлыг хянах системийн, хоорондын замд галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах системийн галт тэрэгний захиргачийн төвлөрүүлэлтийн системийн, цахилгаан тэжээлийн системийн	90%

							bайгууламжийн техникийн шийдлүүдийн техникийн зураг хийгдэж хүлээн авсан. Эхний ээлжийн тоног төхөөрөмж болох балис 2170ш, гол тоологч 29ш, гол тоологчийн блок 14ш, модуль 3ш, кабель зэрэг бараа нийлүүлэгдсэн. Төслийн хийх ажлын төлөвлөгөөний дагуу Амгалан, Туул, Хонхор өртөөдийн цахилгаан төвлөрүүлэлтийн системийг диспетчерийн төвлөрүүлэлтэд холбох дохиоллын зураг төсөл хийгдэж хүлээн авсан ба эдгээр өртөөдөд төсөл хэрэгжүүлэх ажлын бэлтгэл, холбооны ангиудын ажилтнуудыг сургах зорилгоор сургалтын өрөө рүү 6000м кабелийн суурилуулалт хийгдэж байна.	
2	Улаанбаатар төмөр замын гол замын их засварын ажлыг гүйцэтгэх /200 км/ БТГ, ТЗДТБХЗГ	2016-2020	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, бусад эх үүсвэр	149 100	Гол замд 50 км их засварын ажил гүйцэтгэх	37 275	"Улаанбаатар төмөр зам" ХНН нь 2016 онд гол замын 17 км замд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.	90%
4	"Улаанбаатар төмөр зам" ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх ТЗДТБХЗГ	2016-2020	-	-	-	-	Ерөнхий сайдын 2016 оны 71 дугээр захирамжаар байгуулагдсан "Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх талаар оросын талтай хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд ахалж, холбогдох яамдуудын төлөөлөл оролцсон 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж, гишүүд удирдамжийн төсөлд санал ирүүлэхээр тогтсон. Зам, тээврийн хөгжлийн сайд Москва хотод "Оросын төмөр замууд" нээлттэй хувьцаат нийгэмлэгийн ерөнхийлөгчтэй 2016.12.08.-ны өдөр уулзаж, уг асуудлаар хэлэлцэн, Монголын тал дотоодын журмын дагуу холбогдох яамдаас санал авсны дараа саналаа хүргүүлэхээр тохиролцсон.	90%
2.112. "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	1 "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замыг барих ажлыг эхлүүлэх ТЗДТБХЗГ	2016-2020	Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 820 250	Зураг төсөл, ТЭЗҮ-ийг боловсруулж дуусгах, барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь	564 050	МУ-ын Засгийн газрын 2015 оны өдрийн 327 дугаар тогтоол Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр замын зураг төсөл боловсруулах, барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр Концессын гэрээ байгуулах эрх олгосон. МУ-ын Засгийн газрын 2015 оны 420 дугаар тогтоолоор Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Нортэрн рейлвейз" ХХК-д олгосон. Тус компани барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэнээр барилгын ажлыг эхлүүлэхээр байна. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцуулэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, ХЗЯ, ГХЯ, УУХҮЯ, ЭХЯ, БОАЖЯ, СЯ, БХБЯ-аас санал авч ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 2017 оны 2 дугаар улирлаас барилгын ажлыг эхлүүлэх болно. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чиг нь Эгийн голын усан цахилгаан станцын төслийн авто зам болон агаарын шугамын чигтэй	70%

							давхцалтай байгааг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. Уг төслийн ТЭЗҮ-ийг энэ оны 12 дугаар сард дуусгахаар ажиллаж байна. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын 2016.12.28, 2017.01.11-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн.		
2.113. Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, "Хөшиг"-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна.	2	Замын-Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах ТЗДТБХЗГ	2016-2019	Гадаад эх үүсвэр	155 330	Барилгын ажлын гүйцэтгэл 80 хувь	124 264	Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт "Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төсөл"-ийн хүрээнд цэвэр ус дамжуулах 3,5 км шугам, цахилгаан дамжуулах 10/0,4 кВ-н 3 км шугам, 1,6 км авто зам, төмөр зам дээгүүр хөндлөн гарсан гүүр, холбооны шугам, цахилгаан дамжуулах 110/10 кВ-н 4,22 км шугам, дэд станц зэрэг байгууламжууд баригдсан. Логистикийн төвийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчээр "Хятадын төмөр замын 21-р товчоо" компани, хяналтын зөвлөхөөр БНСУ-ын "Сүсонг инженеринг компани", Монгол Улсын "Геозураглал", "NBCC" ХХК-иудын түншлэл ажиллаж, өргөн, нарийн царигийн төмөр замын далан, чингэлэг талбай, авто машины зогсоол, барилгын суурийн газар широоны ажил 50 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт барилгын ажил 40%-тай.	90%
2.114. Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна.	1	Олон улсын нислэгийн сүлжээг өргөжүүлэн тогтвортжуулахад чиглэсэн агаарын харилцааны хэлэлцээ хийх, хэлэлцэр байгуулах, шинэчлэх, холбогдох нэмэлт, өөрлөлт оруулах АТБХЗХ	2016-2020	-	-	-	<ul style="list-style-type: none"> - Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2016 оны 07 дугаар сард Улаанбаатар хотноо байгуулсан - Монгол Улс, БНЧУ-ын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийг Улаанбаатар хотноо БНЧУ-ын элчин сайд И.Гроловатай гарын үсэг зурахаар дипломат шугамаар шийдвэрлэсэн. Ерөнхий сайдын 2016.10.25-ны өдрийн 81 дүгээр захирамжаар БНЧУ-тай байгуулах агаарын харилцааны тухай хэлэлцээр гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбатад олгосон. Хэлэлцээр гарын үсэг зурж баталгаажуулах ажлыг ойрын хугацаанд зохион байгуулж өгөх" хүсэлтийг 2016.11.23-ний өдрийн 01/1808 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. - Камбожийн Вант Улсын Иргэний нисэхийн удирдах байгууллагын төлөвлөгчидтэй уулзалт хэлэлцэр хийж, Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн бичвэрийг тохирон үзэглэж, Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Тохиролцсон хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. - Люксембургийн Их Вант Улс, Мьянмарын Холбооны Улсын Засгийн газартай тохирсон Агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжкуулсан. Люксенбург, Мьянмар, Камбож улсуудтай байгуулах агаарын хэлэлцээр гарын үсэг зурах эрх олгосон Ерөнхий сайдын 2016.03.01-ний өдрийн 29 дүгээр захирамж, 2016.05.16-ны ид 67 дугаар захирамжид тус тус өөрчлөлт оруулж, гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбатад олгох өөрчлөлт хийлүүлгэх хүсэлтийг 2016.10.30-ны 01/1882, 01/1883 тоот албан бичгүүдээр ЗГХЭГ-т хүргүүлсэн - МУ-ын Засгийн газар, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар 	90%	

						хооронд 2000 онд байгуулсан Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг Европын холбооны хууль тогтоомжид нийцүүлэх зорилгоор хэлэлцээрт ёөрчлөлт оруулах асуудлыг МУ-ын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлээд байна.	
2	Орон нутгийн нислэгийг сэргээн тогтвржуулахад агаарын тээврийн компаниудыг татварын бодлогоор дэмжих БТГ, АТБХЗХ	2016-2020	-	-	-	<p>Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээг нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлэх хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох хуульд оруулах нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан үзэл баримтлалыг батлуулахаар Сангийн яам болон Хууль зүйн яаманд 2016.06.06-ний өдрийн 01/2460, 2016.06.07-ны өдрийн 01/2461 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбоотойгоор энэ асуудлыг дахин авч үзэхээр болж, Орон нутгийн агаарын тээврийг сэргээн тогтвржуулах, агаарын тээврийн үнэ тарифыг бууруулах талаар судалгаа хийж санал боловсруулах ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016.11.21-ний өдрийн 93 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p>Ажлын хэсгийг 2016.11.23-ны өдөр хуралдуулж, авиа компаниудын зардал, үр ашгийн тооцоо, орон нутгийн нислэг, орон нутгийн нисэх буудлыг НӨАТ-аас чөлөөлснөөр нислэгийн тийзний үнэд үзүүлэх нөлөөллийн судалгаа, холбогдох тооцоог хийж, 2016.12.02-ны өдрийн хурлаар хэлэлцсэн. Орон нутгийн тийзний үнийг бууруулах арга замын талаар судалж сайдын зөвлөлийн хурлаар танилцуулахад бэлэн болоод байна.</p>	70%
7	Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх замаар бүтэц, менежментийг шинэчлэх АТБХЗХ	2016-2017	-	Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулах	-	<p>Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх замаар бүтэц, менежментийг шинэчлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл, судалгаа, танилцуулга боловсруулж 2016.01.20-ны өдрийн 01/221 тоот албан бичгээр яамдаас санал авсан. Яамдаас ирүүлсэн саналыг нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.</p> <p>Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, зарим яам, агентлагын чиг үүрэг шинэчлэгдсэнтэй холбоотойгоор МИАТ ТӨХК-ийн менежментийг концессоор хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтооюур баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д нэмэлтээр оруулах асуудлыг хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлүүлж өгөхийг хүссэн 2016.12.06 -ны өдрийн 01/2003 тоот албан бичгийг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.</p>	70%

8	Говь-Алтай аймгийн "Алтай" нисэх буудлын хөөрч буух хатуу хүчилттэй зурvas, үерийн далан байгуулах АТБХЗХ, ХШУДАГ	2016-2017	Улсын төсөв	500	Бүрэн ашиглалтад орох	500	Говь-Алтай аймгийн "Алтай" нисэх буудлын хөөрч, буух хайрган болон хатуу хүчилттэй зурvas, явгалах зам, агаарын хөлгийн зогсоол, үерийн далан барих ИНЕГ.ТББ/БУ-55-07 гэрээний дагуу Заабар" ХХК 2900x30м хатуу хүчилттэй зурvas, 2300x35м хайрган хүчилттэй зурvas, 635x15м хайрган болон хатуу хүчилттэй явгалах замууд, 120м*85м бетонон перрон талбай, 3620ум үерийн усны хамгаалалтын далан шуудуу барих ажлыг бүрэн гүйцэтгэсэн. ИНЕГ-ын даргын А/790 дүгээр тушаалаар байгуулагдсан техникийн комисс дүгнэлт гаргасан. Улсын комисс 2016 оны 12 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд ажиллаж, аэродромын барилга угсралтын ажлыг хүлээн авсан.
9	Завхан аймгийн "Доной" нисэх буудлын хөөрч буух хатуу хүчилттэй зурvas, үерийн далан байгуулах АТБХЗХ	2016-2017	Улсын төсөв	2 000	Бүрэн ашиглалтад орох	2 000	Санхүүжилтийн эх үүсвэр нь батлагдаагүй тул 2016 онд ажил гүйцэтгээгүй.
16	Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийг концессын гэрээгээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах АТБХЗХ	2016-2017	-	-	Менежмент ийг гүйцэтгүүлж эхлэх	-	Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг ижил төстэй үйл ажиллагааны туршлага бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх, цаг хугацаа алдалгүй концессыг шууд олгох нөхцөлийг бүрдүүлэх асуудлын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлуулсан. "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 1 дэх хэсэгт 721 заалт болгон "Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийг Хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх концессыг шууд гэрээ байгуулах" гэсэн нэмэлтийг 2015.10.05-ны өдрийн Засгийн газрын 398 дугаар тогтоолоор батлуулав. "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент" төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2015.10.26-ны өдрийн 29 дүгээр захирамжаар байгуулсан. Концессын хэлцэл хийх төсөлд санал ирүүлсэн Мицубиши корпорац, Нарита, Ханеда нисэх буудлууд Жалюкс компаниудын хамтран түншлэл, консорциумын төслийн техникийн үнэлгээг хийсэн. Төслийн саналын хүчинтэй хугацаа нь 2016.07.28-ны өдөр дуусгавар болсонтой холбогдуулан Үнэлгээний ажлын хэсгийн санаачлагаар хугацааг 2016.10.26-ны өдөр хүртэл сунгасан. Ерөнхий Сайдын 2016.09.27-ны өдрийн 63 тоот захирамжаар Ажлын хэсгийг шинэчлэн батлуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2016.10.07-ны өдөр зохион байгуулсан. Уг хурлаар концессын менежмент хийхээр сонирхож ирүүлсэн төслийн техникийн

саналын үнэлгээг эцэслэн баталгаажуулж, санхүүгийн үнэлгээ хийгдсэн Техникийн болон санхүүгийн үнэлгээний дунд үндэслэн хэлцэлд орохоор шийдвэрлэсэн. Хэлэлцээ хийхийн өмнө тодорхой асуудлуудыг сонирхогч талд тавьж хариу авахаар тогтв.

Японы талд 2016.10.12-ны өдрийн 03/1095 тоот албан бичгээр "Төслийн санал хүлээн авах баримт бичиг"-ийн дагуу Ажлын хэсгээс төслийн саналд тодруулга асуултыг хүргүүлсэн. Мөн төслийн хүчинтэй хугацааг сунгах тухай ЗТХЯ-ны ТНБД-ын 2016.10.20-ны өдрийн 03/1201 тоот албан бичгийг оролцогч талд хүргүүлсэн.

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн хүрээнд тулгамдаж буй дараах асуудлуудыг 2016.09.29-ний өдөр зохион байгуулагдах Сайдын зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Үүнд:

1. Төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан барилгын гэрээний маргаантай асуудал болох "үнийн индекс", "эрчим хүчний нэхэмжлэл", "төлбөр хугацаа хоцорч хийгдсний алданги"
2. агаарын хөлгийн шатахуун хангамжийн байгууламжтай холбогдох асуудлууд,
3. шинэ нисэх онгоцны буудлын улсын төсвөөс санхүүжүүлж барих 3-н барилгын санхүүжүүлэлт
4. шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд тулгамдаж буй асуудлууд
5. шинэ нисэх буудлын менежментийг концессын гэрээгээр хэрэгжүүлэх ажлын явц

Сайдын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу дараах арга хэмжээг авсан. Үүнд:

1. Төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан барилгын гэрээний маргаантай асуудал болох "үнийн индекс", "эрчим хүчний нэхэмжлэл", "төлбөр хугацаа хоцорч хийгдсний алданги" зэрэг асуудлыг Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага/JICA-/тай зөвшүүлцэн олон улсын арбитрын шуүхэд шилжүүлэлгүй шийдвэрлэх, түүнчлэн шатахуун хангамжийн туршилт, тохируулга хийхэд ашиглах шатахуун худалдаж авах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, холбогдох арга хэмжээ авах тухай ЗТХЯ-ны ТНБД-ын 2016.10.11-ний өдрийн 03/1080 тоот албан бичгээр хүргүүлсэн.
2. Шинэ нисэх буудлын агаарын хөлгийн шатахуун хангамжийн асуудлаар 2016.10.05-ны өдөр Японы Жайка байгууллагын Монгол Улс дахь оффисын дарга Сатотой уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар TC1 төрлийн шатахуун ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох судалгаанд шаардагдах нэмэлт зардал болон туршилт тохируулга хийхэд

17	Иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх АТБХЗХ	2016-2020	Улсын төсөв	68 000	Дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр урьдчилсан судалгааны ажил хийгдэж эхлэх	18 000 ашиглах шатахуун худалдаж авах хөрөнгийн эх үүсвэрийг Япон улсын хөнгөлттэй зээлийн эх үүсвэрээс эргэн төлөгдхөн нөхцөл санхүүжүүлэх боломжийг олгох тухай хүснэгт тавьсан. Зээлийн үлдэгдлийг тооцож үзээд дахин ярилцахаар болсон. 2016.10.11-ны өдөр ЖАЙКА байгууллагатай уулзалт дахин хийсэн. Уг уулзалтаар түлшний эх үүсвэр болон ЖАЙКА-гаас зээл авах талаар ярилцсан. Түлшний эх үүсвэрийг олгох эсэхээ Жайка байгууллага судалж үзэхээ мэдэгдсэн. 3. Агаарын хөлгийн шатахуун хангамжийн үйл ажиллагааг эрхлэн явуулах операторын оновчтой бүтцийг тодорхойлох, тооцоо судалгааг хийх, туршилт, тохируулга хийсний дараах шатахууны чанарын асуудал, тэдгээрийг хэрхэн борлуулах талаар судалгаа хийж, танилцуулах тухай ЗТХЯ-ны ТНБД-ын 2016.10.12-ны өдрийн 03/1094 тоот албан бичгийг ИНЕГ-т хүргүүлсэн. Ажлын хэсэг 2016.10.25-ны өдөр хуралдаж, төслийн саналын техникийн болон санхүүгийн үнэлгээг нэгтгэн дүгнэж, шаардлага хангасан гэж үзсэн тухайгаа Мицуши корпорацад 2016.11.03-ны өдрийн 03/1422 тоот албан бичгээр мэдэгдсэн. Хариуд нь 2016.11.04-ны өдөр уулзалт зохион байгуулах санал ирүүлсэн. Мөн тус хуралдаанаас агаарын хөлгийн шатахуун хангамжийн операторын үйл ажиллагааг концесс эзэмшигчид хариуцуулах тухай хэлэлцээний үед ярилцахаар шийдвэрлэсэн. Мөн Ажлын хэсэгт хуулийн болон санхүүгийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх зөвлөх компанийг сонгон шалгаруулах, зөвлөх үйлчилгээний санхүүжилтийн асуудлыг Засгийн газарт танилцуулахаар шийдвэрлэсэн болно. Концессын гэрээнд Монголын талаас тавих нөхцөл шаардлагуудыг нэгтэн гаргаж байна.	Иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын агаарын зайл бүрхэх хэмжээнд нийт 13 ADS-B станцыг сууринуулсан.	90%

2.115. Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшигаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.	1	“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулж хэрэгжүүлэх АТБХЗХ	2016-2020	Улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл	18 000	Судалгаа, тооцоо хийгдэх	2 000	<p>Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, эдийн засгийн урьдчилсан төсөөлөл, тооцооллыг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамдаас санал авсан.</p> <p>“Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Иргэний нисэхийн тухай хууль”-ийн шинчилсэн найруулгыг батлуулсны дараа хөтөлбөрийг батлуулах тухай санал ирүүлсэн. Сангийн яамнаас Хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө, зардал шаардлагатай ажлуудын санхүүжилтийн тооцоолол, судалгааг ирүүлэх, төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлтэд үндэслэх тухай санал ирүүлсэн. Бусад яамд дэмжсэн санал ирүүлсэн.</p> <p>Сангийн яамнаас ирүүлсэн саналын дагуу Хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө, зардал шаардлагатай ажлуудын санхүүжилтийн тооцоолол, судалгааг хийж ирүүлэх тухай 2016.08.30-ны өдрийн 09/404, хөтөлбөрийн төсөлд нэмэлт санал авах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тооцоо судалгааг нарийвчлан гаргаж ирүүлэх тухай 2016.11.18-ны өдрийн 09/1724 тоот албан бичгүүдийг ИНЕГ-т хүргүүлсэн.</p>	90%
2.116. Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бус нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.	1	Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан тээврийн салбарын төсөл, арга хэмжээг судалж хэрэгжүүлэх БТГ, ГАЗАР, ХЭЛТСҮҮД	2016-2020	-	-	Төсөл, арга хэмжээг нэг бүрчлэн судлах судалгааны ажлыг хийж эхлэх	-	<ul style="list-style-type: none"> - Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан тээврийн салбарын төсөл арга хэмжээний хүрээнд “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Москва хотноо 2016.12.08-ны өдөр байгуулсан. Хэлэлцээр байгуулагдсантай холбогдон “Бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт олон улсын бага хурлыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Улаанбаатар хотноо 2017 оны 4-5 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөх байна. - Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан Азийн авто замын сүлжээний АН-3 кодтой Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн авто замыг шинэчилж өргөтгэн хөгжүүлэх хүрээнд тус чиглэлийн авто замын хамгийн их хөдөлгөөний эрчимтэй хэсэг болох Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замыг өргөтгэх шинэчлэх талаарх судалгааны ажлын дүнг МУ-ын Засгийн газарт 2016.11.30-ны өдөр танилцуулсан. АХБ-ны техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй ТА8849-МОН төслийн хүрээнд АН-3 чиглэлийн авто замд их засвар шинэчлэлтийн ажлыг тус банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжийг судалж байна. - Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэл буюу Улаанбайшинт-Ховд-Ярант чиглэлийн авто замын сүлжээ нь нийт 756 км бөгөөд тус сүлжээний 556.3 км буюу 74.9 хувийг Улсын төсөв, АХБ-ны зээл, тусламж, БНХАУ-ын EXIM банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр тус тус үе шаттайгаар ашиглалтад оруулсан. Одоо үлдэх байгаа 189.7 км авто замыг АХБ-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2018 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. - Монгол-Оросын Засгийн газар хоорондын Тээврийн ажлын хэсгийн мэргэжилтнүүдийн төвшний уулзалтыг 2016.09.12-ны өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулж, Тээврийн ажлын хэсгийн протоколын 	90%

							төслийг тохирч 2 тал баталгаажуулсан. - Гурав дахь удаагийн гурван улсын тээврийн дэд сайд нарын уулзалтыг МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор 2016 оны 07 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар хойшлогдсон тул бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Уулзалтыг 2016 оны 9 дүгээр сард зохион байгуулахаар ОХУ, БНХАУ-ын тээврийн дэд сайд нарт уулзалтад оролцох тухай урилгын захидлуудыг тус тус хүргүүлж, Оросын талаас уулзалтыг 2016 оны 10 дугаар сарын сүүлээр зохион байгуулах, Хятадын талаас тус уулзалтыг зохион байгуулагдахаас өмнө 3 улсын төмөр замын газруудын төлөөллүүдийг урьдчилан хуралдуулахаар зөвлөлдөх уулзалтын бэлтгэлийг хангах, баримт бичгүүдийн төслийг урьдчилан хэлэлцэх зорилгоор Улаанбаатар хотноо 2016.09.13-ны өдөр гурван талын холбогдох яам, агентлаг болон төмөр замын компаниуд хоорондын мэргэжилтнүүдийн төвшний уулзалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.		
2	Азийн авто замын сүлжээгээр автотээвэр гүйцэтгэх тухай ЗГ хоорондын хэлэлцээрийг эцэслэн байгуулж, хэрэгжүүлэх АТБХЗГ	2016-2017	-	-	Хэлэлцээрийг эцэслэн байгуулах	-	OХУ-ын Москва хотноо 2016.12.08-ны өдөр "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т Монгол, Орос, Хятад гурван улсын Тээврийн сайд нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлуулах ажил хийгдэж байна.	100%	
2.117.	Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.	4	Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол, дэд бүтцийг хөгжүүлж, аюулгүй, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулах ТЗДТБХЗГ, ДАУЗТХ	2016-2020	Тэр, хувийн хэвшлийн түншлэл	4 250	Концессын сонгон шалгаруулалт зарлах	Эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор "Байгаль орчинд ээлтэй" усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч "Усан замын төв будал" талаарх залтыг Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж, УИХ-д өргөн барьсан.	70%
2.118.	Эрэлтэд нийцсэн, хүрээнд байгаа орчинд ээлтэй	1	Төмөр замын зорчигч, ачаа тээврийн үйлчилгээнд орчин үеийн	2016-2020	-	-	"УБТЗ" ХНН-ийн харьяа "Улаанбаатар дахь зорчигчийн вагон депо"-ийн 482 дугаар вагоныг техникийн зураг, төслийн дагуу сэргээгдэх их засварыг хийж, тусгай зориулалтын вагон болгох хийцийг өөрчлөн тоноглон, туршилтын аяллаар шалгаж №16001, код-О-4-2, РД:2076675 дугаар бүхий "Аюулгүй ажиллагаа"-ны гэрчилгээг олгосон. Тус вагоныг 2016.05.20-ны	90%	

тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.	менежментийн аргуудыг бий болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах БТГ, ТЗДТБХЗГ						өдрөөс эхлэн 7 хоногт 2 удаа байнгын тээвэрлэлтэд ашиглаж "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд"-ийг төмөр замаар аюулгүй, ая тухтай зорчих, зорчигч үйлчилгээний стандартын шаардлагыг хангаж ажилласан. Төмөр замын объектыг коджуулах тухай О 920-2, О+920; О+920-1,2; О+914 санамжуудыг MNS 920; MNS920-1,2; MNS914 стандарт болгон батлуулахаар ажиллаж байна. Төмөр зам, далайн тээврийн техникийн хорооны хурлаар 2016.09.30-ны өдөр хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийн дагуу сайжруулж байна.	
2	Аюулгүй, найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэн 400-аас доошгүй автобусаар парк шинэчлэх БТГ, АТБХЗГ	2016-2020	Улсын төсөв, гадаад эх үүсвэр	80 000	100 автобус авах	20 000	<p>Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /"ЭЗХХАС"/-гаас 2011-2018 онд авах зээлийн тухай МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авах зээлийн хөрөнгөөр "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 459 дүгээр тогтоолын дагуу төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр МУ-ын Сангийн яам, БНСУ-ын БНСУ-ын Экспорт-импорт банкны хооронд гэрээ байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Эхний шатны төслийг 2016 онд зохион байгуулагдан АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын үйлчилгээнд ажиллуулахаар 43 автобус худалдан авах 5.5 сая ам.долларын санхүүжилтийн Зээлийн гэрээ байгуулж хэрэгжүүлсэн. - Хоёрдугаар шатны төслийг 25 сая.ам.долларын санхүүжилт бүхий төслийг хэрэгжүүлэхээр МУ-ын Сангийн яам, БНСУ-ын Экспорт-импорт банкны хооронд зээлийн гэрээг 2016.07.17-ны өдөр байгуулсан. Энэхүү гэрээнд автобус худалдан авах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тусгасан. Зээлийн гэрээний дагуу 2016.11.09-ний өдөр ЭКЗИМ банктай хамтарсан ажил хэргийн уулзалт зохион байгуулж, холбогдох асуудлаар санал солилцож хэрэгжүүлэх ажлын чиглэлээр ажиллаж байна. 	90%
5	Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх БТГ, АТБХЗГ	2016-2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 700	-	-	<p>Тээврийн хэрэгсэлд бүртгэл хяналтын RFID суурилсан систем бүрдүүлэх, туршилт, судалгааны ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулж, 2016.02.04-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот хурлын өрөөнд хэлэлцүүлэг хийсэн. Туршилтын программын ажил хийгдэж дууссан. 2016.06.13-ны өдрийн Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн судалгааны ажил дэмжигдсэн.</p> <p>2017 оны төсвийн тухай хуулийн төсөлд RFID системийг нэвтрүүлэх ажлын төсвийг суулгахаар санал оруулсан боловч улсын төсөвт суугаагүй болно. Иймд RFID системийг сууринуулах ажлыг гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэхээр Хөгжлийн банк болон Үндэсний хөгжлийн газарт санал хургуулээд байна.</p>	90%
6	Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх ажлыг зохион	2016-2017	Гадаад эх үүсвэр	1 065	Төсөл хэрэгжих	1 065	<ul style="list-style-type: none"> - 2016 оны жилийн эцсийн байдлаар улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх гэрээтэй 4429 тээврийн хэрэгсэл бүхий 130 аж ахуйн нэгжээс 93 аж ахуйн нэгжийн 3251 тээврийн хэрэгсэлд буюу 73,4 хувьд бүртгэлийн GPS систем суурилагдсан бөгөөд "Автотээврийн үндэсний 	70%

	байгуулах БТГ, АТБХЗГ						төв" ТӨҮГ-ын "Хөдөлгөөний удирдлага, хяналтын төв"-ийн сүлжээг өргөтгэн программыг сайжруулах, улс хоорондын байнгын болон аюултай ачаа тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн GPS-ийг хяналтын төвтэй холбох ажлыг эхлүүлээд байна.	
7	Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх БТГ, СНХ	2016-2020	Зам, тээврийн салбарын нормчлолын сан	4 000	Хөтөлбөр боловсруулах	1 000	- Мөн хот доторх болон хот орчмын зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж буй 1250 автобус, троллейбусанд байрлал тогтоох төхөөрөмж, жолоочийн мэдээлэл дамжуулах консол, зорчигчийн суух, буух хаалгын дэргэд карт уншигч төхөөрөмж, 4 шт хяналтын камерийг сууринуулж, 250 цэгт карт борлуулах буюу цэнэглэх үйл ажиллагааг зохион байгуулсан. 450,0 мянган карт борлуулснаар нийт зорчигчдын 60 гаруй хувь нь картаар зорчих байна. АХБ-ны санхүүжилтээр "Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулах ажлын бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн зорчигчийн тасалбар худалдаалах үйл ажиллагааг хөнгөвчлөх, тээврийн үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх замаар TVM /ticket vending machines/-аар тасалбар олгох үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.	
2.120. Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлын хүрээнд "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг 2015 оноос хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөлтөөр хотын босоо тэнхлэгт Нисэх-7 буудал чиглэлд - 23 км, хэвтээ тэнхлэгт ХМК- 3, 4-р хороолол - Шархад чиглэлд - 19,5 км, нийт 42,5 км замыг барьж байгуулах, 57км замыг засварлах, 146 тусгай замын автобус худалдан авах, 10 уулзварт өргөтгөлийн ажлууд хийгдэнэ. Төслийн санхүү, эдийн засгийн үнэлгээ тооцоо, ТЭЗҮ хийгдсэн. Одоогоор нарийвчилсан зураг төсөв хийгдээгүй байгаа. "Нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хуулийн төсөл батлагдсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, дүрэм, удирдах хорооны бүрэлдэхүүн, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлагдсан. 2016.02.26-ны өдрийн Нийслэлийн засаг даргын А/154 захирамжаар "Нийслэлийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангах, Азийн хөгжлийн банкны төслийн баг, судалгааны багуудын ажлыг дэмжих, шуурхай зохицуулалтаар хангах,	100%						

							хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад холбогдох техникийн шийдлийг гаргаж хамтран ажиллах үүрэг бүхий техникийн ажлын хэсэг байгуулсан. 2016.02. 26-ны өдөр тус ажлын хэсэг АХБ-ны төслийн баг, Нийтийн тээврийн чадавхыг бэхжүүлэх ТА8212-МОН болон Төр хувийн хэвшлийн түншлэлийн бэхжүүлэх ТА8985-МОН төслийн багтай уулзалт хийж АХБ-ны тусгай замын автобусны коридор сонголтын талаар саналтай танилцсан. Дээрх төслийн хүрээнд техникийн туслалцааны олон улсын судалгааны багууд ажиллаж байна.		
2.121. Автозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн үүсвэрэйг шаттай нэмэгдүүлнэ. эх үе	1	Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний бэлэн байдлыг жилийн туршид хангах, арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх АЗБХЗГ, ЗАЗХ	2016- 2020	Улсын төсөв	189 810	Арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх	39 310	Улсын төсвээр батлагдсан 8.0 тэрбум төгрөгөөр Олон улсын болон улсын чанартай 12917 км авто зам, замын байгууламжид зайлшгүй хийгдэх урсгал засвар, арчлалтын төлөвлөгөөг замын чиглэл бүрээр хучилтын төрөл, насхилт, хөдөлгөөний эрчим, цаг уурын бүсчилэлээс хамааруулан тооцож гарган Зам, тээврийн сайдын 2016 оны 21 дүгээр тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахаар засвар арчлалт хариуцсан мэргэжилтнүүд 4, 5 дугаар саруудад "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ийн бүс нутаг хариуцсан инженерүүд, зам хариуцагч компанийн захирал, инженерүүдтэй хамтран газар дээр нь хийгдэх ажлын төрөл, тоог хэмжээ, байршилгээ тогтоосон. Тогтоосон ажлын тоо хэмжээг үндэслэн төсөв зохиож хийгдэх ажлын график төлөвлөгөөг боловсруулан батлуулж биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. Олон улсын болон улсын чанартай 12917 км авто зам, замын байгууламжид хийгдэж буй засвар арчлалтын ажлын өдөр тутмын хяналтын зөвлөх үйлчилгээг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Төсвийн тодотголоор 12.0 тэрбум төгрөг нэмж батлагдсан тул олон улсын болон улсын чанартай авто замуудад хийгдэх засвар, арчлалтын ажлыг дээрхийн адил дахин зохион байгуулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 43 дугаар тушаалаар батлуулан, нэмэлт гэрээг зам хариуцагч 28 компани бүртэй байгуулан гүйцэтгүүлсэн.	90%
	2	Улаанбаатар- Дархан- Алтанбулаг, Улаанбаатар- Арвайхээр, Дархан- Эрдэнэт, Улаанбаатар- Чингис, Налайх-Чингис чиглэлийн нийт 504 км авто замд их засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх БТГ, АЗБХЗГ	2016- 2020	Улсын төсөв	226 800	126 км авто замд их засвар, шинэчлэл- лийн ажил хийж гүйцэтгэх	56 700	2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км, Элсэнтасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг Улсын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын их засварын ажлын зураг төслийн ажлыг 2016 оны 07 дугаар сард "МСПС жи ар" ХХК-иар гүйцэтгүүлсэн. Тус авто замын эхний ээлжийн 17 км авто замын их засварын ажлын тендерийг зарлаж, гэрээ байгуулахаар шийдвэрлээд байна.	90%

3	Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Арвайхээр, Улаанбаатар-Чингис, Налайх-Чойр, Хархорин-Цэцэрлэг, Улаангом-Хандгайт, Өлгий-Улаан байшинт чиглэлийн 725 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэх БТГ, АЗБХЗГ	2016-2020	Улсын төсөв	145 000	181 км авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх	36 250	2016 оны улсын төсөвт авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх хөрөнгө тусгагдаагүй. Улаанбаатар-Дархан чиглэлийн 6 км авто замын ээлжит засварын ажлын гүйцэтгэл 90%. Гэрээг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан.. 2017 оны Улсын төсвийн төсөлд УБ-Арвайхээр чиглэлийн 62 км авто замд ээлжит засвар, УБ-Чойр чиглэлийн 59 км авто замд ээлжит засвар, УБ-Дархан чиглэлийн 64 км авто замд их засвар хийх санал хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.
4	Чигэстэй, Онги, Түргэн, Цалгар, Усан хоолой, Цагаан сүм, Тэс, Хэрлэн, Буянт, Хуурай хөндий, Хараагийн нийт 1128.5 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлийн ажил хийх АЗБХЗГ, БТГ	2016-2020	Улсын төсөв	16 400	282.1 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэх	4 100	2016, 2017 оны Улсын төсвийн төсөлд Чигэстэй, Онги, Түргэн, Цалгар, Усан хоолой, Цагаан сүм, Тэс, Хэрлэн, Буянт, Хуурай хөндий, Хараа голын нийтдээ 1128.5 у/м гүүрэнд их засвар хийх санал хүргүүлсэн боловч батлагдаагүй. Улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтын ажлын хөрөнгөөр Чигэстэй голын 54 у/м, Цагаан сүмийн 51 у/м гүүрэнд засварын ажлыг гүйцэтгүүлж, одоогоор 1 137.8 сая төгрөгийн ажил гүйцэтгээд байна. Мэн Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн голын 217.1 у/м гүүрэнд гэнэтийн эвдрэл гарч, гүүр нурах нөхцөл үүссэн тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2016.05.31-ний өдрийн 286 дугаар тогтоолоор 3.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс гаргуулахаар шийдвэрлүүлж, гүйцэтгэгчийг шалгаруулан их засварын ажлыг гүйцэтгүүлж байна. Ажлын гүйцэтгэл 30%. Их засварын ажлын гэрээний хугацаа 2017.07.01-ний өдөр дуусна.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт №3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.

3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	7	Авто замын салбарт дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цемент ашиглан цемент бетон хүчилттай авто зам барьж, өртөг зардал хямд авто замын дэвшилтэг техник, технологи нэвтрүүлэх, үндэсний стандартыг бий болгох БТГ, СНХ	2016-2020	Гадаад эх үүсвэр	50 000	Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цементээр бетон хүчилттай авто зам барих, замын өртөг зардлыг бууруулах, ашиглалтын чанарыг сайжруулах техник технологийг боловсруулах	10 000	Авто замын салбарт дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цементбетон хүчилттай авто зам барьж, өртөг зардал хямд авто замын дэвшилтэг техник технологи нэвтрүүлэх судалгааны ажлыг Зам, тээврийн салбарын норм нормативын сангийн 2015-2016 оны ажлын төлөвлөгөөнд тусган, хийж гүйцэтгэсэн. Ажлын тайлангийн хэлэлцүүлэгийг 2016 оны 12 сард хийсэн. Зам, тээврийн салбарын норм нормативын сангийн 2017 оны төлөвлөгөөнд тусгуулахаар дээрх судалгааны хурээнд хийх стандартуудын жагсаалтыг гаргасан.	90%
---	---	---	-----------	------------------	--------	--	--------	---	-----

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт №4.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялагийг хамгаалах, хомсдоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бус нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинт бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.4.5. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.	2	Нийслэл болон аймгийн төвд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний авто буудал барих БТГ, АТБХЗГ	2016-2020	Төр, хувийн хэвшлийн түншлэл	57 000	-	-	Зураг төсөл нь бэлэн болсон 11 аймгийн төвд автобуудал барих 32 тэрбум төгрөгийг 2016 болон 2017оны улсын төсөвт тусгуулах саналаа Сангийн яаманд хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. Хөрөнгө оруулах санхүүгийн бусад эх үүсвэр хайж байна. Засгийн газрын 2015 оны 306 дугаар тогтооолор батлагдсан "Олон улсын чанартай авто замын дагуу олон улсын жишигт нийцсэн Авто замын дагуух үйлчилгээний төв байгуулах концессын зүйлийн жагсаалт"-ын хурээнд 2016.11.28-ны өдөр Архангай, Хөвсгөл, Дорнод, Орхон, Сүхбаатар, Говьсүмбэр, Өвөрхангай, Говь-Алтай, Увс, Дорноговь, Төв аймгийн Засаг даргын тамгын газрын дэд бүтэц хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүд, орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах санал солилцох уулзалтыг зохион байгууллаа. Уулзалт үеэр орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагуудын зүгээс бүтээн байгуулалтын ажлыг хийхээр дараах тодорхой саналуудыг гаргав. Үндэс: 1. Увс, Архангай, Хөвсгөл зэрэг аймгуудад автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах ажлын	70%
--	---	---	-----------	------------------------------	--------	---	---	--	-----

							санаачилгыг гаргалаа. 2. Орхон аймагт автобуудал барихаар гэрээ байгуулсан компаниудын төлөөлөл уулзаж ойрын хугацаанд барилгын ажлыг эхлүүлэхээр тохиролцов.
--	--	--	--	--	--	--	--

ТАБ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт №5.1. Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална.

5.1.3. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.	Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх, шинээр боловсруулах, дэд салбарын талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэх БТГ, ГАЗАР, ХЭЛТСҮҮД	1	2016-2020	-	Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүү дэд шинэчлэл хийж, баримт бичиг батлагдах	-	"Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016.11.24-ний өдрийн 96 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг ажлын хэсэг нь "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын баримт бичгийг "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-тай уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ЗТХЯ-ны Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр боловсруулж байна. Монгол Улсын Их хурал болон Засгийн газраас баталсан Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д нийцсэн эсэхийг хянаж дүгнэлт гаргах, "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д нэмэлт өөрчлөлт оруулах болон "Төрөөс авто тээврийн талаар баримтлах бодлого"-ыг боловсруулах ажлыг ЗТХЯ-ны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан болно. Бусад салбарын бодлогын баримт бичгийг "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-тэй нийцүүлэн боловсруулах ажлыг 2018 оноос эхлэн хийхээр төлөвлөж байна.	90%
---	--	---	-----------	---	---	---	--	-----

Тэргүүлэх зорилт №5.6. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсан харилцаа, улс тэр, худалдаа, эдийн засаг, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагаагаар хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлж, бус нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцож, хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлнэ.

5.6.1. Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл болон Монгол Улс, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлж, худалдаа, эдийн засгийн	ОХУ-ын нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжин өнгөрөх тээврийн нөхцөлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулахад БТГ,	5	2016-2020	Улсын төсөв	450	ТЭЗҮ-ийг гаргах	200	"Төмөр замаар ачаа дамжуулан тээвэрлэх нөхцөлийн тухай" Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулахаар 8 зүйл бүхий хэлэлцээрийн төслийг боловсруулж, 2016 онд 4 удаа талууд уулзаж, хэлэлцээрийн төслийг солилцсон. 2016 оны 10 дугаар сард Оросын тал Хэлэлцээрийн төслид саналлаа ирүүлсэн. Монголын тал зарчмын зөрүүтэй саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна. Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 3 яамнаас санал авваар бичиг явуулсан Гадаад харилцааны яамнаас хариу ирүүлээгүй байна.	70%
--	---	---	-----------	-------------	-----	-----------------	-----	---	-----

харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хоёр хөршийн далайн боомтыг ашиглах, тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	ТЗДТБХЗГ							
6	БНХАУ-ын нутаг дэвсгэрээр далайд гарах, дамжин өнгөрөх, олон улсын зэрэглэл бүхий авто болон тэмер замын боомт нэмж байгуулах асуудлыг хамтран шийдвэрлэх БТГ, ТЗДТБХЗГ, АТБХЗГ	2016-2020	Улсын төсөв	650	Бүх талын ТЭЗҮ-ийг хийх	200	<p>БНХАУ-ын дарга Си Жиньпин 2014 оны 08 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр байгуулсан "Монгол – Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр"-ийг шинэчлэн байгуулах тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Улсын төмөр замын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт төмөр замын 4 боомт нэмж байгуулахаар тохиролцсоны дагуу хоёр улсын хил дээрх төмөр замын холболтын цэгийг тодорхойлох ажлыг шуурхайлан дуусгаж, хоёр улсын Засгийн газар хооронд 2004 онд байгуулсан "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр"-т нэмэлт өөрчлөлтийг оруулах ажлын хүрээнд хоёр талын ажлын хэсэг 2016.05.02-ны өдөр Шивээхүрэн-Сэхэ (хилийн тэмдэг 573), Бичигт-Зүүнхатавч (хилийн тэмдэг 1050), Сүмбэр-Рашаан (хилийн тэмдэг 1083-2) төмөр замын хил отглолын цэгүүдийг тогтоосон бөгөөд Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн холболтын цэгийг тогтооход хоёр тал саналын зөрүүтэй байна.</p> <p>Хамтарсан ажлын хэсэг дахин Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомт дээр ажилласан бөгөөд Хятадын талын санал болгож буй 703 дугаар хилийн тэмдгийн орчим холбох нь Монголын талаас ирэх төмөр замын далангийн газар шорооны ажил үлээмж их ба барилга угсралтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай болоод байна. Монголын талаас 700 дугаар хилийн тэмдгийн орчим холбох саналтай байна.</p>	50%
5.6.5. Худалдааны гол түвш болон бусад улстай худалдааг улам хөнгөвчлөхөд чиглэсэн хэлэлцээр байгуулах чиглэлээр холбогдох судалгааг эхлүүлж, худалдааны тарифын болон тарифын бус хориг саадыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах БТГ	Гуравдагч улсаас БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин Монгол Улсад импортлогдож буй бараа, бүтээгдэхүүний тарифын болон тарифыг бус хориг саадыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах БТГ	2016-2020	Улсын төсөв	730	Хориг саадыг арилгах чиглэлээр ажиллах, тодорхой ахиц гаргах	120	<p>Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколын хавсралт Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг ЗГ-ын хуралдаан, УИХ-ын АБГБ-ын Байнгын хорооны хуралдаан, УИХ дахь МАН-ын Бүлгийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэв. Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт нэгдэн орох хуулийн төслийг УИХ-ын 2016.11. 24-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>Хэлэлцээрт нэгдэн орсноор Далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд хөгжлийн түншүүдээс дэмжлэг, туслалцаа авах хууль ёсны эрх баталгаажих, худалдааг хөнгөвчлөхд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад худалдааны зардлыг бууруулах, экспортыг дэмжих, дамжин өнгөрөх тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, хил, гаалийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх боломж бүрдэнэ.</p>	90%

ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД

6.14. Өмнөговь аймаг

1. Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хүчилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана.	1	Өмнөговь аймгийн Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хүчилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах БТГ, АЗБХЗГ	2016-2020	Улсын төсөв	200 000	Ажлын гүйцэтгэлийг 25 хувьд хургэх	50 000	Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302.7 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг Өмнөговь аймаг орон нутгийн хөрөнгөөр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгчээр "Дарданговь" ХХК ажиллаж байгаа бөгөөд эхний 56 км авто замыг барьж Улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан.	100%
2. Даланзадгад-Цогтцэций чиглэлийн хатуу хүчилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана.	2	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шартээг-Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хүчилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах БТГ, АЗБХЗГ	2016-2019	Төр, хувийн хэвшлийн түншлэл	40 700	Ажлын гүйцэтгэлийг 33 хувьд хургэх	13 500	Mongol Ulсын Zasgийn gазрын 2016 onы 12 dugaar sарын 28-ны өдрийн 63 dugaar xуралдааны тэмдэглэлээр эдийн засгийн хүндэрлэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил эхлээгүй Өмнөговь аймгийн төвийг Нийслэлтэй холбосон авто замын "Шартээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хүчилттай авто замуудын барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулах шийдвэр гарсан бөгөөд 2016 онд барилгын ажил хийгдэж эхлээгүй байна. Концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан тухайн чиглэлийн авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газар хариуцаж байгаа бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд уг төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих эрх одоогоор шилжиж ирээгүй байна.	-

6.16. Сэлэнгэ аймаг

1. Орон нутгийн чанартай нийт 200 км автозамыг барьж байгуулна.	1	Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 112 км авто зам барих БТГ, АЗБХЗГ	2016-2018	Улсын төсөв	44 800	Замын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	24 000	Mongol Ulсын Zasgийn gазрын 2016 onы 12 dugaar sарын 28-ны өдрийн 63 dugaar xуралдааны тэмдэглэлээр эдийн засгийн хүндэрлэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил эхлээгүй Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хүчилттай авто замуудын барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулах шийдвэр гарсан бөгөөд 2016 онд барилгын ажил хийгдэж эхлээгүй байна. Концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан тухайн чиглэлийн авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газар хариуцаж байгаа бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд уг төслийг	-
---	---	--	-----------	-------------	--------	--	--------	--	---

							хэрэгжүүлэх, хяналт тавих эрх одоогоор шилжиж ирээгүй байна.	
6.19. Ховд аймаг								
2. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр баруун бүсийн босоо тэнхлэгийн автозам барина. /Өлгий-Ховд 100 км/	2	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам барих /Өлгий-Ховд 100 км/ АЗБХЗГ	2016-2018	Гадаад зээл	86 300	Газар шорооны ажлыг дуусгах, хүчилтийн ажлыг дуусгаж ашиглалтад оруулах	86 300	<p>1. Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр "Чайна Хуаши Ентерпрайзис Лимитэд" компанийтай барилгын ажлын гэрээ байгуулсан. 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн. Одоогоор хөрс хуулалт 85,71%, далангийн дүүргэлт 66,7%, ухмал 14,58%, суурин додоо үе 42.53% хийгдсэн. Нийт барилгын ажил 17.2%-тай байна.</p> <p>2. Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хүчилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр "НКВ интернейшнл холдинг" ХХК-тай барилгын ажлын гэрээ байгуулсан. 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр авто замыг ашиглалтад оруулна. Барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн. Одоогоор хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 79,57%, ухмал 96,93%, суурин додоо үе 72.28%, гүрийн ажил 30.54%, хоолойн ажил 23.05% хийгдсэн. Нийт барилгын ажил 27.44%-тай байна.</p>
НИЙТ							90%	
85.4%								

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ